




ИНФОГРАФИК: ГОЛЛОХ ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Өмнөх сартай харьцуулсан үзүүлэлт





ЭКСПОРТЫН ГОЛ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ХЭМЖЭЭ БОЛОН ДУНДАЖ ҮНЭ

Экспортын гол бүтээгдэхүүний хэмжээ болон дундаж үнийг графикаар оны эцсийн байдлаар харуулав.



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

ИНФОГРАФИК- САР ТУТМЫН БУСАД ҮЗҮҮЛЭЛТҮҮД



ЭДИЙН ЗАСАГ ЯМАР БАЙХ ВЭ?- ТААМАГ (ОУЭЗБ)

ДНБ-ий өсөлт: 2022 онд: **6%**,
Инфляци: 2022 онд: **8.2%**,
Урсгал тэнцэл: 2022 онд: **-10.2%**-тай байхыг Азийн хөгжлийн банк (АЗХБ) 2021 оны тайланд прогноз хийсэн байна.

Эх сурвалж: <https://bit.ly/30pG2Et>


ДНБ-ий өсөлт: 2022 онд: **7.5%**
Инфляци: 2021 онд: **7.3%**,
ДНБ-д эзлэх урсгал тэнцэл: 2022 онд: **-8.5%**- Олон улсын валютын сан (ОУВС)-ийн тайланд дурдсан байна.

Эх сурвалж: <https://bit.ly/3qx1ORq>

ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД: УЛСЫН ТӨСӨВ, ВАЛЮТЫН ХАНШ, ИНФЛЯЦИ, ГАДААД ХУДАЛДАА

Төсвийн тэнцэл 2-р сарын байдлаар 32.1 тэрбум төгрөгийн ашигтай гарлаа.


Улсын нэгдсэн төсвийн орлого өмнөх жилийн мөн үеэс 58.5 хувиар өссөн бол, зарлага 40 хувиар нэмэгдэж төсвийн тэнцвэржүүлсэн нийт тэнцэл 32.1 тэрбум төгрөгийн ашигтай гарав. Төсвийн алдагдал өнгөрсөн оны мөн үеэс 128.5 тэрбум төгрөгөөр буурсан үзүүлэлттэй байна.

**Ам.долларын ханш өмнөх сараас 7.84 төгрөгөөр өсчээ.**


Хоёрдугаар сард Монголбанкны төгрөгийн ам.доллартай харьцах нэрлэсэн дундаж ханш өнгөрсөн оны мөн үеэс 7.50 төгрөгөөр нэмэгдэж, өмнөх сартай харьцуулахад 7.84 төгрөгөөр өсч 2857.20 төгрөг болов. 1-р сард гадаад валютын нөөц 3.9 тэрбум төгрөг буюу өнгөрсөн сараас -9.64 оны эхнээс 13 хувиар буурч, өнгөрсөн оны мөн үеэс 9.6 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

**Инфляцийн түвшин 14.2%**


Хэрэглээний үнийн индекс улсын хэмжээнд 2022 оны 2-р сарын байдлаар өмнөх сараас 1.1 хувиар нэмэгдэж, өмнөх оны мөн үеэс 14.2 хувиар, оны эхнээс 3.1 хувь өсөв. Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2022 оны 2 дугаар сард өмнөх оны мөн үеэс 14.2 хувиар өсөхөд хүнсний бараа, ундаа, усны бүлгийн үнэ дүнгээрээ 18.0 хувь, согтууруулах ундаа, тамхины бүлгийн үнэ дүнгээрээ 7.5 хувь, хувцас, бөс бараа, гутлын бүлгийн үнэ дүнгээрээ 11.1 хувь, орон сууц, ус, цахилгаан, хийн болон бусад түлшний бүлгийн үнэ дүнгээрээ 15.0 хувь, эм тариа, эмнэлгийн үйлчилгээний бүлгийн үнэ дүнгээрээ 13.1 хувь, тээврийн бүлгийн үнэ дүнгээрээ 21.5 хувиар тус тус өссөн нь голлон нөлөөлсөн байна.

**Гадаад худалдааны тэнцэл 142.5 сая.ам долларын ашигтай гарав.**

2022 оны хоёрдугаар сард нийт барааны эргэлт 2217.9 тэрбум төгрөг буюу өмнөх оны мөн үеэс 1.24 хувиар буурсан бол экспорт өмнөх сараас 11.5 хувь буурч, импорт өмнөх оны мөн үеэс 12.5 хувиар нэмэгдэж гадаад худалдааны тэнцэл 142.5 сая ам.долларын ашигтай гарав.



2-Р САРЫН ОНЦЛОХ: ЗЭЭЛ

Эх сурвалж: www.mongolbank.mn

ААН, байгууллага, иргэдэд олгосон нийт зээлийн өрийн үлдэгдэл 2022 оны 2-р сард өмнөх сараас 1.4 хувиар, өнгөрсөн оны мөн үеэс 24.2 хувиар тус тус өсч 21.2 их наяд төгрөг болов. Чанаргүй зээлийн хэмжээ 2157 тэрбум төгрөг болж, өмнөх сараас 3.3 хувиар өсч, өнгөрсөн оны мөн үеэс 6.9 хувиар өссөн байна. Нийт зээлд эзлэх чанаргүй зээлийн өрийн үлдэгдэл 10.1% байна. Хугацаа хэтэрсэн зээлийн өрийн үлдэгдэл 2022 оны 2 дугаар сарын эцэст 1.0 их наяд төгрөг болж, өмнөх сараас 6.3 (0.6%) тэрбум төгрөгөөр өсөж, өмнөх оны мөн үеэс 307.1 (22.7%) тэрбум төгрөгөөр буурчээ. Хугацаа хэтэрсэн зээлийн өрийн үлдэгдэл нийт зээлийн өрийн үлдэгдлийн 4.9 хувийг эзэлж, өмнөх оны мөн үеэс 3.0 нэгж хувиар буурчээ.

САРЫН ОНЦЛОХ

ЗОЧИД БУУДЛЫН САЛБАРЫН ОРЛОГО 14.1 ХУВИАР НЭМЭГДЭВ.

- Зочид буудлын салбарын орлого 2021 оны эцэст 188.5 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеийнхээс 23.2 тэрбум төгрөг буюу 14.1 хувиар нэмэгдэж, бодит өсөлт нь 6.8 хувь байна. Үүнд 3 ба түүнээс дээш одтой буудлын орлого 14.5 (13.8 хувь) тэрбум, зэрэглэлгүй зочид буудал, амралтын газрын орлого 8.8 (15.7 хувь) тэрбум төгрөгөөр нэмэгдсэн нь голлон нөлөөлжээ. Зочид буудлын салбарын орлого 2021 оны 10 дугаар сард 29 тэрбум төгрөг болж өмнөх сарынхаас 5.9 (25.8 хувь) сая төгрөгөөр нэмэгдэж, харин 11 дүгээр сард 27.6 тэрбум төгрөг болж, өмнөх сарынхаас 1.4 (4.7 хувь) тэрбум төгрөгөөр багассан байна.

БАНКУУДАД 81 ТЭРБУМ ТӨГРӨГИЙН ЭХ ҮҮСВЭР ОЛГОВ.

- Монголбанкнаас 100 тэрбум хүртэл төгрөгийн репо арилжаа зарлаж банкуудад 81 тэрбум төгрөгийн эх үүсвэрийг олголоо. Тус арилжаанд Худалдаа хөгжлийн, Голомт, Богд банк зэрэг банк оролцож дээрх санхүүжилтийг авах хүсэлт ирүүлжээ. Мөнгөний бодлогын хорооны 2021 оны болон энэ оны 1 дүгээр тогтоолд үндэслэн төв банк урт хугацаат репо арилжаа зохион байгуулав. Мөнгөний бодлогын хорооны тогтоолын дагуу уул уурхайн бүс экспорт, боловсруулах үйлдвэрлэлийн салбарт олгох зээлийн хугацааг 3 хүртэл жил болгон, нэг зээлийн дээд хэмжээ 3 тэрбум төгрөг байсныг нэмж, зээлийн нөхцөлд нэмэлт, өөрчлөлт оруулав.

Эх сурвалж:

1. Статистикийн бюллетень, 2-р сар 2022 он, Үндэсний статистикийн хороо
2. Статистикийн бюллетень, 2-р сар 2022 он, Монголбанк
3. www.1212.mn, www.mongolbank.mn, www.montsame.mn.